



ОРХОН АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ДЭРГЭДЭХ ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2022 оны 06 сарын 03 -ны өдөр

Дугаар А/30

Эрдэнэт

Үзлэг шинжилгээ зохион байгуулах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь заалт, Эрүүл мэндийн сайдын 2021 оны А/30 тоот “Сүрьеэгийн тусламж үйлчилгээ үзүүлэх журам, заавар батлах тухай” тушаал, Глобал сан, аймгийн Эрүүл мэндийн газартай “Сүрьеэгийн тохиолдлын хавьтлыг илрүүлэг үзлэгийг зохион байгуулах тухай” хамтарсан гэрээ, Монголын сумын эмч, мэргэжилтнүүдийн холбооны захирлын 2022 оны 05 дугаар сарын 05-ны өдрийн А/35 тоот албан бичгийг тус, тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Сүрьеэгийн хавьтлын хяналтын үзлэг шинжилгээний хамралтыг сайжруулах арга хэмжээг зохион байгуулах ажлын хэсгийн бүрэлдэхүүн”-ийг нэгдүгээр, “Эмчлэгдэж байсан болон шинээр илэрсэн тохиолдлын сүрьеэтэй өвчтөний хавьтлыг бүрэн тогтоож, тархвар зүйн заалтын дагуу эрт илрүүлэх, хяналтандаа авч, эмчлэх үйл ажиллагааны удирдамж”-ийг хоёрдугаар, шаардагдах төсвийг гуравдугаар хавсралтаар тус, тус баталсугай.
2. Арга хэмжээг үр дүнтэй, хариуцлагатай зохион байгуулж ажиллахыг ажлын хэсгийн ахлагч, гишүүдэд үүрэг болгосугай.
3. Үйл ажиллагааг зохион байгуулахад шаардагдах 1.400.000 /нэг сая дөрвөн зуун мянга/-н төгрөгийг нэмэлт санхүүжилтийн данснаас гаргахыг Салбарын санхүү бүртгэл, мэдээлэл, нягтлан бодохын ажилтан /Н.Чулуун-Эрдэнэ/-д зөвшөөрсүгэй.
4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн эрүүл мэндийн төвийн ахлах мэргэжилтэн /А.Баярхүү/-д даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Д.СҮХЭЭ

Эрүүл мэндийн газрын даргын 2022 оны
06 дугаар сарын 22-ны өдрийн
150 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт

АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Ажлын хэсгийн ахлагч: Нийгмийн эрүүл мэндийн төвийн ахлах мэргэжилтэн
Гишүүд: БОЭТ-ийн сүрьеэ диспансер
БОЭТ-ийн дүрс оношлогооны рентген техникч
МСТН-ийн ажилтан
Нарийн бичиг: ЭМГ-ын халдвар судлаач

**ЭМЧЛЭГДЭЖ БАЙСАН БОЛОН ШИНЭЭР ИЛЭРСЭН ТОХИОЛДЛЫН СҮРЬЕЭТЭЙ
ӨВЧТӨНИЙ ХАВЬТЛЫГ БҮРЭН ТОГТООЖ, ТАРХВАР ЗҮЙН ЗААЛТЫН ДАГУУ ЭРТ
ИЛРҮҮЛЭХ, ХЯНАЛТАНД АВАХ, ЭМЧЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ УДИРДАМЖ**

2022.06.02

Үндэслэл:

Улсын хэмжээнд 2021 оны 12 сарын байдлаар сүрьеэгийн 2709 шинэ тохиолдол бүртгэгдсэн нь олон улсын тооцсон нийт шинэ тохиолдлын 31%-ийг илрүүлсэн байна. Өөрөөр хэлбэл улсын хэмжээнд 8000 гаруй сүрьеэтэй өвчтөн оношлогдоогүй буюу илрүүлээгүй байна гэж үзэж байна.

Монгол улсын Засгын газар, Эрүүл мэндийн яамнаас дээрх хэрэгжилтийг хангахын тулд шинэ илэрч байгаа сүрьеэгийн тохиолдлын хавьтлын хяналтыг сайжруулах, далд халдварыг илүүлэх нь нэн шаардлагатай байгааг чухалчлан энэ чиглэлээр эрт илрүүлгийг эрчимжүүлэхийг үүрэг болгосон.

Орхон аймагт 2019-2021 онд сүрьеэгийн тооцоолсон өвчлөл 600 байсан боловч 240 тохиолдол бүртгэгдэж өвчлөлийн илрүүлэлт 40%-тай байгаа нь илрүүлэлтийн арга хэмжээ хангалтгүй байгааг харуулж байна.

Иймд сүрьеэ өвчтөний хавьтлыг бүрэн тогтоох, тархварзүйн заалтын дугуу эрт илрүүлэх, хяналтад авах ажлыг эрчимжүүлэх арга хэмжээг сум, багийн түвшинд нэмэгдүүлж ажиллах шаардлагатай байна.

Зорилго:

Аймгийн хэмжээнд сүрьеэ өвчтөний хавьтлыг бүрэн тогтоож, тархварзүйн заалтын дагуу эрт илрүүлэх, хяналтад авснаар сүрьеэгийн тархалтыг бууруулах.

Зорилт:

- 2021 онд шинээр илэрсэн 53 сүрьеэгийн тохиолдлыг бүрэн хяналтандаа авч бүртгэлжүүлэн эмчилгээнд хамруулж, төгс эмчлэх, үр дүнг тооцох,
- Өвчтөний гэр бүлийн болон ойрын хавьтлыг судлан бүрэн хяналтад авах ба урьдчилан сэргийлэх хяналтын шинжилгээг хугацаанд нь хийж, дүгнэлт гарган ажиллах,
- Эмчлэгдэж байсан сүрьеэгийн тохиолдлуудыг дахин судалж, төгс эмчлэгдсэн эсэх талаар үнэлгээ, дүгнэлт өгч, дахин шинжилгээнд бүрэн хамруулах.

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

- Сүүлийн 3 жилд сүрьеэгээр өвчилсөн иргэдийн хавьтлын судалгааг баг, сумаар шинэчлэн нягталж үзлэгт хамрагдаагүй хавьтлыг үзлэгт бүрэн хамруулах, үргэлжлэх шатны эмчилгээ болон хяналтын шинжилгээг цаг тухайд нь авч ажиллах

- Сүрьеэгийн хавьтлуудын бусад орон нутаг руу шилжсэн тохиолдолд одоо оршин сууж буй засаг, захиргааны нэгж, байгууллагуудад мэдэгдэх ба мэдэгдсэн тухай хяналтын карт дээр тэмдэглэж, тасралтгүй хяналтыг тогтоох
- СӨЭМТ-үүдийн хавьтлын үзлэгийн үйл ажиллагааг эхлүүлэх бэлтгэл ажлыг хангах, илрүүлэлт хамрагдах иргэдэд мэдээллийг урьдчилан хүргэх,
- Шинээр илэрсэн сүрьеэгийн хавьтлуудыг нэг бүрчлэн судалж илрүүлэх, хяналтанд авах бэлтгэл ажил хангах,

№	Үзлэг хийгдэх ӨЭМТ	Хугацаа
1	Анхын-Оч ӨЭМТ	2022.06.08
2	Нийцэл ӨЭМТ	2022.06.09
3	Мэндцэцэн ӨЭМТ	2022.06.10
4	Мөнхийнгэгээ ӨЭМТ	2022.06.13
5	Мөнхсүндрэл ӨЭМТ	2022.06.14
6	Учралтбаяр ӨЭМТ	2022.06.15
7	Үйлсбадрах ӨЭМТ	2022.06.16
8	Энхжихмандариваа ӨЭМТ	2022.06.17

Хугацаа: 2022 оны 06 сарын 08- аас 06 сарын 17хүртэл

Хүрэх үр дүн:

- Сүрьеэгийн эрт илрүүлэлтийг нэмэгдүүлэх замаар сүрьеэ өвчний хүндрэл, нас баралтыг бууруулна.
- Аймгийн хэмжээнд сүрьеэтэй өвчтөний хавьтлыг бүрэн тогтоож, тархвар зүйн заалтын дагуу эрт илрүүлэн хяналтад авч сүрьеэгийн тархалтыг бууруулна.
- Эмэнд тэсвэртэй сүрьеэгээс урьдчилан сэргийлнэ.

УДИРДАМЖ БОЛОВСРУУЛСАН: АЗСХӨАХМ

Билгүүнээ

Б.БИЛГҮҮНЭЭ

ХЯНАСАН: НЭМТАМ

А.Баярхүү

А.БАЯРХҮҮ

Эрүүл мэндийн газрын даргын 2022 оны
0.6 дугаар сарын 12-ны өдрийн
1/10 дугаар тушаалын гуравдугаар хавсралт

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨСӨВ:


№	Зардлын төрөл	Хэгжих нэгж	Тоо хэмжээ	Нэг бүрийн үнэ	Нийт үнэ
1	Шатахуун	Л	60	2490₮	540.000₮
2	Хоол	Ш	40	8000₮	320.000₮
3	Утасны нэгж	Т	16	20000₮	320.000₮
4	Илүү цаг	Т	1	220.000₮	220.000₮
	Нийт төсөв				1.400.000₮

Боловсруулсан

Эдийн засагч  Д.Отгондэлгэр

Хянасан

Ерөнхий нягтлан

 Н.Чулуун-Эрдэнэ